



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 42

Аварга

**Бруцёллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/165 дугаар тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын А/408 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцёллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад сумын бүх тугал, хурга, ишиг болон отрын бүс нутгийн тугал, ишиг, хурганд 2024 оны 09 дүгээр сарын 25-ний өдрөөс эхлэн 20 хоногт багтаан зохион байгуулж ажиллахыг "Батмэнд сүрэг", "Цагаантан-Эрдэнэ", "Баянхааны сүрэг" мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдийн захирал, малын эмч (Ч.Хоролмаа), (Ц.Хүрэлбаатар), (С.Сарантуяа), (О.Батболд) нарт даалгасугай.

2. Багийн малчдад урьдчилан мэдэгдэж зар хүргэх, малчдын малыг бэлэн байлгах, тарилгын хашаа хоолойг малчдаар бэлтгүүлэх, малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж, хүн хүч, тээврийн хэрэгслээр хангаж ажиллахыг багийн Засаг дарга (Ж.Март), (Г.Пунцагжамц), (Л.Мөнхбат), (Г.Батнасан), (Т.Чинзориг) нарт үүрэг болгосугай.


3. Шаардагдах вакцин эм бэлдмэлийг татан авч, мал эмнэлгийн аж ахуй нэгжүүдэд хуваарилах, мэргэжил арга зүйгээр хангаж, тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон иргэд, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, тарилгын материалыг хугацаанд нь хүргэж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Д.Баярмаа)-д үүрэг болгосугай.

4. Бруцёллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах мал, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

5. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Баттулга) -д хариуцуулсугай.

ДАРГА

Э.ТӨГӨЛДӨР



Засаг даргын 20~~24~~ оны ~~09~~ дугаар сарын ~~26~~-ны
өдрийн ~~1/6~~ дугаар захирамжийн хавсралт

ДЭЛГЭРХААН СУМЫН 2024 ОНД БРУЦЁЛЛЁЗ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХАВРЫН ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛ, ВАКЦИНЫ ХУВААРЬ

Д/ Д	МЭҮН-ийн нэр	Хамруулах мал / толгой/				Вакцин тун		Вакцин тун		Шингэлэгч мл
		тугал	Хурга	ишиг	бүгд	Штам-19	ширхэг	Rev-1	ширхэг	
1	Цагаантан - Эрдэнэ	480	5100	4100	9680	480	6	23	23	10160
2	Батмэнд сүрэг	560	5900	4500	10960	560	7	26	26	11520
3	Баянхааны сүрэг	320	4843	3157	8320	320	4	20	20	8640
	Дүн	1360	15843	11757	28960	1360	17	69	69	30320